

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР СУРГУУЛЬ



**НИЙГМИЙН УХААНЫ БАГШ О.БАТСАЙХАНЫ
2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН**

2019 ОН

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР СУРГУУЛИЙН НИЙГМИЙН УХААНЫ БАГШ О.БАТСАЙХАНЫ 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН

1.Төлөвшил

- **Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал**
- ✓ 2018-2019 оны хичээлийн жилийн турш Сургалтын алба, НУЗАН, бусад ЗАН, багш нарын хамтаар хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө, төлөвлөлт, ээлжит, нэгж болон тусгай хэрэгцээт хичээл хамтран бэлтгэн, хэлэлцүүлэг зохион байгуулж ажилласан.
- ✓ Эцэг эх, асран хамгаалагчидтай ганцаарчилсан зөвлөгөө, 2017-2018 оны хичээлийн I, II III, IV улирлын туршид
- ✓ 2018-08-24 “Бага сургуулийн шав тавих ёслол”-ын үйл ажиллагаа
- ✓ 2018-09-01-03 2018-2019 оны хичээлийн жилийн нээлт
- ✓ 2018-09-04-05 Мэргэжил сурталчилах өдрүүдийг НУЗАН-ийн хамт олны хамтаар амжилттай зохион байгуулав.
- ✓ 2018-09-07 Сургуулийн багш нарын бага хурал
- ✓ 2018-09-10 2018-2019 оны хичээлийн жилийн I улирлын II долоо хоногт сурагчдын судалгаа гарган сургуулийн мэдээллийн санд оруулав.
- ✓ 2018-09-10 ҮЭ-ийн ээлжит хурал
- ✓ 2018-09-12 ЧДБГ, ЧДЭМГ-аас хамтран зохион байгуулсан урьдчилан сэргийлэх үзлэг
- ✓ 2018-09-20 “Нэг баг нэг арга зүй” хэлэлцүүлэгт (монгол хэл) хичээлийн видео бичлэгт оруулан ажиллав.
- ✓ Тэргүүний заах аргын нэгдэл шалгаруулах шалгаруулалт
- ✓ 2018-09-27 Жижүүр багш
- ✓ 2018-09-28 “Багш нарын буухиа тэмцээн”-д оролцож багаараа тусгай байр
- ✓ 2018-10-04 Жижүүр багш
- ✓ 2018-10-05 “Дэлхийн болон Монголын багш нарын баяр”-ын үйл ажиллагаа
- ✓ 2018-10-12 Сурагчийн дэвтрийн үйл ажиллагааны оншилгоо
- ✓ 2017-10-13 “Үндэсний мод тарих өдөр”-т оролцон сургуулийн ногоон талбайн цэвэрлэгээ үйлчилгээний ажилд оролцон ажиллав.
- ✓ 2018-10-05 “Сурагчийн нэг өдөр”-ийг ахлах ангийн сурагчдын хамтаар
- ✓ 2018-10-17 Монгол Германы АСА академийн захирал Ш.Амартүвшингийн зохион байгуулсан “Лужин стратеги” сургалт
- ✓ 2018-10-01-26 МУБИС-ийн багш Ph.D, дэд проф С. Түмэндэлгэрийн хамтаар дадлагжигч оюутан М.Солонготуяагийн хэлэлцүүлэгт хичээлд зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав.
- ✓ 2018-10-29 “Түүх, нийгмийн ухааны үнэлгээний шалгуур”-ыг боловсруулан хэлэлцүүлэг өрнүүлэв.
- ✓ 2018-10-29 Үнэлгээний шалгуур боловсруулах сургалт
- ✓ 2018-11-1-26 МУБИС-ийн багш Ph.D, дэд проф С. Түмэндэлгэрийн хамтаар дадлагжигч оюутан Т.Анугийн хэлэлцүүлэгт хичээлд зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав.
- ✓ 2018-11-05 Багш нарын хурал
- ✓ 2018-11-14 “Багшаа сонсьё” үйл ажиллагаанд НУЗАН хамтаар захирал Ц.Цолмонбаатартай уулзах уулзалт
- ✓ 2018-11-19 “Эерэг бол гоё” аяны хүрээнд “Эерэг энергийг бэлгэлье” сургалт
- ✓ 2018-11-20 3D лабораторийн нээлтийн үйл ажиллагаа

- ✓ 2018-11-22 Сургуулиас Мэдээлэлзүйн багш Шинэхүүгийн удирдлаган дор зохион байгуулсан “Moodle” программын танилцуулах сургалт
- ✓ 2018-11-29 Багш Х.Ардахын Нийгмийн ухааны сонгон судлах хэлэлцүүлэгт хичээлд оролцов.
- ✓ 2018-11-29 Багш Н.Анударийн Нийгмийн ухааны сонгон судлах хэлэлцүүлэгт хичээлд оролцов.
- ✓ 2018-11-29 Жижүүр багш
- ✓ 2018-12-03 Сургуулиас Мэдээлэлзүйн багш Шинэхүүгийн удирдлаган дор зохион байгуулсан Moodle программын танилцуулах сургалт
- ✓ 2018-12-03 “Цэнэглэх цаг”-эрүүл мэндийн танилцуулах сургалт
- ✓ 2018-12-08 “Эко сургууль” төслийн хүрээнд тус сургуулийн эрсдлийн судалгааны сургалт
- ✓ 2018-12-08 8а, 8г ангид Иргэний боловсролын үйл ажиллагааны цагаар “Эрхээ ухамсарлаж, бусдын эрхийг хүндэтгэн харилцах нь сэдвээр хэлэлцүүлэгт хичээл багаараа зохион байгуулав.
- ✓ 2018-12-10 Олон улсын хүний эрхийн өдөрт зориулан “Эрхээ дархлаажуулъя, та ч бас эрхээ хамгаал” сэдэвт ээлжит хичээлийг НУЗАН-ийн багш нарын хамтаар бэлтгэн зохион байгуулав.
- ✓ 2018-12-10 7-11-р ангийн түүхийн хичээлийн гарааны онооны сорилыг боловсруулан үнэлгээнд дүн шинжилгээ хийн ажиллав.
- ✓ 2018-12-10 Олон улсын хүний эрхийн өдөрт зориулан “Эрхээ дархлаажуулъя, та ч бас эрхээ хамгаал” сэдэвт ээлжит хичээлийг НУЗАН-ийн багш нарын хамтаар бэлтгэн, сурагчдын бүтээлээр үзэсгэлэн зохион байгуулав.
- ✓ 2018-12-11 7 дугаар ангийн сурагчдын дунд “Миний мэдэх Чингис хаан” эссэ бичлэгийн уралдаанд шалгарсан бүтээлийг нийтэд сурталчилав.
- ✓ 2018-12-11-12 Сургуулийн модны чимэглэл
- ✓ 2018-12-12 Сургуулийн сүлд модны нээлтийн үйл ажиллагаа
- ✓ 2018-12-17-18 Мэдлэг чадварын сорилыг амжилттай зохион байгуулав.
- ✓ 2018-12-19 Жижүүр багш
- ✓ 2018-12-20 ЧДБГ-ын ойн баярын хүндэтгэлийн үйл ажиллагаа МҮЭСТО
- ✓ 2018-12-20 Сургуулийн заалны чимэглэл
- ✓ 2018-12-22 6-11-р ангийн шинэ жилийн үйл ажиллагааны зохион байгуулалт
- ✓ 2018-12-24-28 Багш нарын зөвлөгөөний хурал
- ✓ 2018-12-28 ҮЭЧХ-ны талаар багш, ажилчдын дунд явуулсан үйл ажиллагаа
- ✓ 2019-01-07 Төрийн албан хаагчийн судалгааг шинэчилсэн бүртгэл
- ✓ 2019-01-08-18 “Moodle” программын сургалт, шалгалт
- ✓ 2019-01-10 Гадаад хэлний “Тамирчин багш” тэмцээний хөгжөөн дэмжигч
- ✓ 2019-01-11 7б ангийн сурагчийн асран хамгаалагчидтай хийсэн уулзалт зөвлөгөө, мэдээлэл
- ✓ 2019-01-15 2018-2019 оны хагас жилийн тайлан хамгаалалт
- ✓ 2019-01-16 ЧД-ийн ТНУ-ны тамирчин багш тэмцээн
- ✓ 2019-01-23 ЧД-ийн ҮЭ-ийн багш нарын “Бид хамтдаа” тэмцээн
- ✓ 2019-01-28 Багш нарын шуурхай хурал
- ✓ 2019-02-08 Сургуулийн золголт
- ✓ 2019-02-13 Багш нарын шуурхай хурал
- ✓ 2019-02-18 Магистр багш нарын судалгааны баг, хурал
- ✓ 2019-02-19 НБГ-аас зохион байгуулсан олимпиад зохион байгуулах хурал
- ✓ 2019-02-25 Цэнэглэх цаг-“Өсвөр насны сурагчдын үе тэнгийн дарамт дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх багшийн арга зүй” сургалт
- ✓ 2019-02-26 “Moodle” программын сургалт

- ✓ 2019-02-27 МҮОНТ-ээс зохион байгуулсан “Ээждээ захидал бичээрэй” уралдаанд 7-9-р ангийн сурагчдыг хамруулав.
- ✓ 2019-02-28 “Moodle” программын сургалт, танилцуулах өдөрлөг
- ✓ 2019-02-28 Багш нарын шуурхай хурал
- ✓ 2019-03-01 Багш нарын шуурхай хурал
- ✓ 2019-03-03 Багш нарын шуурхай хурал
- ✓ 2019-03-05 72-р сургууль дээр зохион байгуулсан “ЧД-ийн Түүхийн олимпиад”-ын шагнал гардуулах үйл ажиллагаа
- ✓ 2019-03-05 Багш нарын шуурхай хурал
- ✓ 2019-03-07 “ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн хүндэтгэлийн үйл ажиллагаа
- ✓ 2019-03-11 Цэнэглэх цаг
- ✓ 2019-03-11 ҮЭ-ийн тайлант сонгууль
- ✓ 2019-03-18 “Монгол цэргийн өдөр”-ийн хүндэтгэлийн үйл ажиллагаа
- ✓ 2019-03-20 Гамшгийн үеийн сургуулилалтын мэдээлэл, танилцуулга
- ✓ 2019-03-21 Багш нарын шуурхай хурал
- ✓ 2019-03-21 Гамшгийн үеийн сургуулилалт
- ✓ 2019-03-22 “Moodle” программын сургалт
- ✓ 2019-03-22 Эцэг эхийн нээлттэй хаалганы өдөрлөг
- ✓ 2019-03-25 Цэнэлэх цаг – “Авилгагүй ил тод орчин
- ✓ 2019-03-26 Жижүүр багш
- ✓ 2019-03-26 Эцэг эхийн нээлттэй хаалганы өдөр
- ✓ 2019-03-27 Иргэн төслийн хүрээнд 9в ангийн сурагчид сургуулийн цайны газрын захирал, дотоод хяналтын менежер нартай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулав.
- ✓ 2019-03-28 Эцэг эхийн нээлттэй хаалганы өдөр
- ✓ 2019-03-29 “Moodle” программын сургалт
- ✓ 2019-04-03 Багш нарын хурал
- ✓ 2019-04-04 Сургууль танилцуулах зураг авалт
- ✓ 2019-04-09 “Moodle” программын сургалт
- ✓ 2019-04-09 Цэнэлэх цаг
- ✓ 2019-04-10 “Moodle” программын сургалт
- ✓ 2019-04-11 Эко явган аялал
- ✓ 2019-04-12 Н.Энхбаярын ном хандивлах үйл ажиллагаа
- ✓ 2019-04-12 Сургалтын менежер М.Цогзолмаад хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаа
- ✓ 2019-04-17 Онцгой байдлын бэлэн байдлын бэлтгэл сургуулилалт
- ✓ 2019-04-19 “Moodle” программын сургалт
- ✓ 2019-04-19 Багш нарын шуурхай хурал
- ✓ 2019-04-20 Их хотын их цэвэрлэгээ
- ✓ 2019-04-22 Багш нарын шуурхай хурал
- ✓ 2019-04-22 Жижүүр багш
- ✓ 2019-04-22 Цэнэглэх цаг – Багш нарын VII Их хурлын мэдээлэл
- ✓ 2019-04-23 Багш Х.Ардахын 8д ангид нийгмийн ухааны хичээлээр явуулсан хэлэлцүүлэгт хичээл
- ✓ 2019-04-25 Улсын гамшгаас хамгаалах бэлтгэл сургуулилалт
- ✓ 2019-04-25 Бие бялдарын сорил
- ✓ 2019-04-26 “Иргэн төсөл”-ийн үндэсний шалгаруулалт
- ✓ 2019-05-01 Багш нарын шуурхай хурал
- ✓ 2019-05-03 Багш нарын шуурхай хурал

- ✓ 2019-05-06 Хэлний баярын нээлтийн үйл ажиллагаа
- ✓ 2019-05-06 “Иргэн төсөл” хэрэгжиж буй ангиудын бүтээсэн цомог танилцуулах хэлэлцүүлэгийг Иргэний боловсролын төвийн ажилтан С.Ариунаагийн хамтаар сургуулийн номын санд зохион байгуулав.
- ✓ 2019-05-06 Цэнэглэх цаг
- ✓ 2019-05-08 Хэлний баярын зураг авалтын зохион байгуулагчаар
- ✓ 2019-05-08 Жижүүр багш
- ✓ 2019-05-09-10 МХО-д хэлний баярын зохион байгуулагчаар
- ✓ 2019-05-11 Үндэсний мод тарих өдөр
- ✓ 2019-05-24 ШУА-ийн Философийн хүрээлэн, академич С.Нарангэрэлийн зохион байгуулсан “Монголчуудын ёс суртахууны боловсрол” хэлэлцүүлэг
- ✓ 2019-05-27 Бие бялдарын сорил, судалгаа
- ✓ 2019-05-28 Багш нарын шуурхай хурал – Амжилтын гараа
- ✓ 2019-05-29 НУЗАН-ийн хурал
- ✓ 2019-05-31 Сургуулийн захиргаа, ҮЭ-ээс хамтран зохион байгуулсан “ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн үйл ажиллагаа
- ✓ 2019-06-06 Жижүүр багш
- ✓ 2019-06-06 НУЗАН-ийн тайлан хамгаалалт
- ✓ 2019-05-27-06-14 Анги дэвших, мэдлэг чадвар болон улсын шалгалт зохион байгуулах, задгай даалгавар засах, хэлэлцүүлэг
- ✓ 2019-06-12 Төгсөх ангийн зохион байгуулалт, үйл ажиллагаанд тус тус оролцон ажиллав.

7 дугаар ангиудад сурагч болон багийн оролцоог чухалчлан хичээл бүрийн цаг тухай бүрт нь үнэлж дүгнэж идвэхжүүлж ажилласан. 9 дүгээр ангиудад сурагч, баг, хамтын оролцоонд тулгуурлан хичээл, хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагт үнэлгээ өгч хамтран ажилласан. Оролцоог идэвхитэй үнэлэх шалгуур үзүүлэлт болгосон нь идэвх оролцоонд нөлөөлж, өөрөө өөрийгөө болон бусдыг, бусадтай өөрийгөө харьцуулан үнэлж дүгнэж чаддаг болсон. 11 дүгээр ангиудад сургалтын идэвхитэй аргуудыг хэрэглэн, бие даан, багаар ажиллах аргыг голчлон хэрэгжүүлсэн. Хичээлийн явцад тогмол үнэлгээний идэвхитэй аргуудыг хэрэглэж ирснээр суралцагчдын идвэхи, оролцоо, хариуцлага сайжирсан. Сурагчдын ялгаатай байдлыг харгалзан, түвшин тус бүрт тохирсон даалгаврыг өгснөөр сурагчдын оролцоо нэмэгдэж, хичээлд хандах хандлага өөрчлөгдсөн.

Түүх, нийгмийн ухааны үг хэллэг, ухагдахууныг ашиглахын сацуу түүхэн болон улс төрийн газарзүйн зураг уншиж, дасгалын зураг дээр ажиллаж, эх сурвалж, баримт бичиг, тохиолдол дээр ажиллах чадвартай болж, суралцагсад бусдын өмнө өөрөө өөрийгөө зөвөөр илэрхийлэхэд суралцсан.

7 дугаар ангийн сурагчид хичээл дээр тогтвортой сууж сураагүй, анхаарал төвлөрөлт сул, ангийн ажил болон гэрийн даалгавар, шалгалтын ажлын гүйцэтгэл муу, сурагчдын тоо их байгаа нь сургалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн түүхийн хичээл, иргэний боловсролын үйл ажиллагааны цаг биентамирын хичээлийн өмнө түүний дараа эсвэл хичээлийн сүүлийн цагуудад орж байгаа нь сургалт хэвийн жигд, тасралтгүй явагдахад бие болоод сэтгэлзүй, цаг хугацааны хувьд тохиромжгүй байдлыг үүсгэж байгаа юм. Анги удирдсан багш, эцэг эх, асран хамгаалагч, сурагчидтай ганцаарчлан уулзаж зөвлөгөө, мэдээлэл, чиглүүлэг өгч ажилласан ба тодорхой үр дүнд хүрч байна. 9 дүгээр ангийн сурагчдын хичээл, үйл ажиллагаанд оролцох идвэхи харьцангуй хэвийн байгаа нь сайшаалтай. Гэвч зарим ангиудын сурагчид хичээлийн хэрэглэгдэхүүн, гэрийн даалгавар, бие даалтыг огт хийдэггүй, түүнд анхаарал тавьдаггүй, ор нэр төдий хичээлд сууж байгаа байдал нь хэвийн зүйл болсон байна. 11 дүгээр ангийн сурагчдын хувьд харьцангуй

хичээлд хандах хандлага өмнөх жилүүдийг бодвол сайжирсан ч хичээл, даалгавар, бие даалтыг цаг тухайд нь гүйцэтгэдэггүй эсвэл бие биенээсээ хуулах байдал анги нийтэд түгээмэл үзэгдэл болсон байна. Цаашид бие даан бүтээлчээр хандах хандлага, оролцоог хөгжүүлэх шаардлага бий болжээ.

- **Дэгийн хэрэгжилт, дадал хэвшил суусан байдал**

7 дугаар ангиудад зөв, эмх цэгцтэй, санаа бодлоо давхцалгүйгээр үзэл бодлоо илэрхийлж хэвших, хүмүүс, хамт олонтой зохистой харьцахад анхаарал хандуулан ажилласан. Гэрийн даалгавар болон ангийн үйл ажиллагаа, даалгаврыг тогтмол шалгаж хэвшил. Сайхан, зөв үг хэллэг, дохио зангаа үгийг хэлж хэвших, хүмүүс, хамт олонтой зохистой харьцах, бусдад туслах ач тусыг ойлгох биеэ зөв авч явах бусдад үлгэрлэх тал дээр анхаараллаа. 9 дүгээр ангиудад сурагчдын идвэхи оролцоо, дэвтэр хөтлөлт, гэрийн даалгаврыг үнэлгээнд хамааруулан үзэж зөвлөгөө, мэдээлэл өгч хичээл, даалгавар бүрэн гүйцэд хийхэд анхаарч ажиллаа. Зөв, эмх цэгцтэй, санаа давхцахгүйгээр үзэл бодлоо илэрхийлж хэвших, хүмүүс, хамт олонтой зохистой харьцах, бусдад туслах ач тусыг ойлгох биеэ зөв авч явах бусдад үлгэрлэх тал дээр анхаарал хандуулан ажилласан. 11 дүгээр ангиудад бие даан, багаар ажиллахад анхаарал хандуулан идвэхи оролцоо, дэвтэр хөтлөлт, даалгавар, бие даалтын ажил зэргийг үнэлгээнд хамааруулж, алдаа дутагдалд нь зөвлөгөө, мэдээлэл өгч хичээл, даалгавар бүрэн гүйцэд хийхэд анхаарч ажилласан. Явцын үнэлгээг гол шалгуур болгож, шалгалт, сорилд бэлтгэж ирсэн нь суралцагсдыг үнэлж, дүгнэж, зөвлөгөө өгч ажилласанаар суралцагчдын оролцоо нэмэгдэж хичээлд хандах хандлагад өөрчлөлт гарсан болно.

Сурагчид шинэ долоо хоногийн эхний цагт хичээл эхлэхэд төрийн дуулалаа хүндэтгэн дуулах, багштай мэндлэх, алжаал тайлах дасгал хийх, хичээл сургалтын явцад гар утас хэрэглэхгүй байх, өөр хичээл, хичээлийн даалгаврыг бусад зүйл хийх, хоорондоо хичээлийн бус агуулгатай зүйл ярихгүй байх зэрэгт анхаарал хандуулан ажиллаж дадал хэвшилд сургасан.

- **Бусадтай харилцах зан чанар**

7 дугаар ангиудад мэндлэх, хүндлэх, уучлалт гүйх, зөв зохистой болон түүх, нийгмийн ухааны үг хэллэг хэрэглэх зэрэгт анхаарал хандуулан ажиллаа. Бусдыгаа хүндэлж, үгийг нь хүлээцтэй сонсож сурснаар харилцаа, хандлагад өөрчлөлт ороход нөлөөлсөн. Цаашид нөхөрсөг, хамт олонч зан чанарыг төлөвшүүлэхэд анхааран ажиллах болно. 9 дүгээр ангиудад өөрийгөө болон бусад харилцаанд оролцогч талаа хүндэтгэж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх тал дээр анхаарал хандуулан ажиллаа. Нөхөрсөг, хамт олонч, тусч, эвсэг зан чанарыг төлөвшүүлэхэд голлон анхаарсан ба бусдыгаа хүндэлж, үгийг нь хүлээцтэй сонсдог зан чанарт суралцуулсан. Суралцагсдыг өөрийн зорилготой суралцаж, хүсэл мөрөөдөлдөө хүрэхэд нэг алхам урагшлахад анхааран ажиллаа. 11 дүгээр ангиудад өөрийгөө болон бусад харилцаанд оролцогч талаа хүндэтгэж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх тал дээр анхаарал хандуулан ажилласан. Бусадтай зөв харилцах харилцааг төлөвшүүлж, сурагчийн хувийн болон баг, хамт олны зөв зан чанарыг хөгжүүлэхэд анхаарч байна. Оролдлого, оролцоо, хандлагыг нь үнэлж дүгнэснээр хүүхдийн зан байдал, өөртөө итгэх байдал зэрэгт өөрчлөлт орж өөртөө итгэлтэй болсон. Мөн түүнчлэн бусдын хүсэлт, шаардлагыг хүлээн авч анхаарал татаж буй асуудлыг шийдвэрлэхэд анхаарал хандуулан ажилласан. Цаашид багш сурагчид, эцэг эх, асран хамгаалагч, бусад оролцогчид харилцан бие биенээ хүндэтгэн харилцаж, бие биенээ хүлээцтэй сонсож, өөрийн үзэл бодлоо бусдад зөв илэрхийлэхэд анхаарах хэрэгтэй. Зарим эцэг эх, асран хамгаалагчидтай сурагчдын зан байдал, сэтгэлзүйд гарч буй өөрчлөлт, бусад асуудлаар ганцаарчилан ярилцлага өрнүүлж, зөвлөгөө, мэдээлэл өгч хамтран ажилласнаар тодорхой үр дүнд хүрсэн.

- **Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил, дадал хэвшил зан чанарын байдал**

Түүх, нийгмийн ухаан, иргэний боловсролын судлагдахуун нь сурагчдын хувийн болон багийн оролцоон дээр тулгуурлаж явагддагаараа бусад судлагдахуунаас ялгаатай бөгөөд нийгэмийн харилцаанд сурагчдыг шууд татан оролцуулахаас гадна суралцагчид нийгмийн толь болдог. Иймээс ч бусдыгаа хүндэлж, үгийг нь хүлээцтэй сонсож сурснаар харилцаа, хандлагад өөрчлөлт ороход нөлөөлсөн. Цаашид нөхөрсөг, хамт олонч зан чанарыг төлөвшүүлэхэд анхааран ажиллах болно. Сурагчид өөрийгөө болон бусад харилцаанд оролцогч талаа хүндэтгэж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх тал дээр анхаарал хандуулан ажиллаа. Нөхөрсөг, хамт олонч, тусч, эвсэг зан чанарыг төлөвшүүлэхэд голлон анхаарсан ба бусдыгаа хүндэлж, үгийг нь хүлээцтэй сонсдог зан чанарт суралцуулсан. Суралцагсдыг өөрийн зорилготой суралцаж, хүсэл мөрөөдөлдөө хүрэхэд нэг алхам урагшлахад анхааран ажиллаа. Оролдлого, оролцоо, хандлагыг нь үнэлж дүгнэснээр хүүхдийн зан байдал, өөртөө итгэх байдал зэрэгт өөрчлөлт орж өөртөө итгэлтэй болсон. Мөн түүнчлэн бусдын хүсэлт, шаардлагыг хүлээн авч анхаарал татаж буй асуудлыг шийдвэрлэхэд анхаарал хандуулан ажилласан. Нийт сурагчдын багшид хандах хандлага нь эерэг сайн, сурч мэдэхийн төлөө ажилладаг бол зарим цөөн тооны суралцагчид хичээлийн явцад саад бэрхшээл учруулдаг, гэрийн даалгавар болон бие даалтын ажлыг цаг тухайд нь гүйцэтгэдэггүй байдал ажиглагддаг.

- **Жижүүр багшийн үнэлгээ**

2018-2019 оны хичээлийн жилийн хугацаанд нийт 9 удаа жижүүр багшийн үүргийг нийт 270 оноотойгоор үнэлж дүгнүүлж гүйцэтгэсэн. 2018-09-27, 2018-10-04, 2018-11-29, 2018-12-19, 2019-02-24, 2019-03-26, 2019-04-22, 2019-05-08, 2019-06-06

- **Судалгаа шинжилгээ, ямар үр дүнд хүрсэн эсэх, ажилласан байдал**

- ✓ Сурагчдын ирц (өвчтэй, чөлөөтэй, тасалсан)-ээр дүн шинжилгээ хийж эцэг, эх асран хамгаалагч, анги удирдсан багшид танилцуулан үнэлгээнд хамааруулсан.
- ✓ Хичээлийн идэвхи, оролцоо (хувийн, багийн, явц, гэрийн даалгавар, бие даалт)-ыг тэмдэглэн үнэлгээнд хамааруулан үзснээр сурагчдын идэвхи оролцоонд тодорхой ахиц гарсан.
- ✓ Сурагчийн дэвтрийн үйл ажиллагааны оншилгоог хичээлийн явцад хийж үнэлгээжүүлж улирлын эцэст нэгдсэн дүнг сурагч, эцэг, эх асран хамгаалагч, анги удирдсан багшид танилцуулан үнэлгээнд хамааруулсан.
- ✓ Шалгалт, шүүлэг (гарааны оноо, явцын, нэгж болон ээлжит хичээлийн, улирлын, мэдлэг чадвар, анги дэвших, улсын шалгалт гм)-ийг тооцож ажилласнаар сурагчийн хувийн амжилт, бууралт, түвшин түүний өөрчлөлт зэргээр
- ✓ Стандарт хэрэгжилт, үнэлгээний харьцуулалтыг хийж мэргэжлийн багш болон сурагч, эцэг эх, асран хамгаалагч хамтран ажиллахад мэдээллийн бааз суурь болж байдаг.
- ✓ Дэмжлэг хэрэгтэй сурагчидтай ажилласан ажилласан байдлын судалгааг гаргаж цаашид хэрхэн хамтран ажиллах, үнэлгээнд гарч буй өөрчлөлт, асран хамгаалагчдаас суралцагчидад тавьж буй анхаарал хэрхэн өөрчлөгдөж буйг тооцон ажиллаа.
- ✓ Эцэг эх, асран хамгаалагчтай ажилласан байдлын судалгааг гарган ажилласан.
- ✓ Эко сургууль төслийн хүрээнд эрсдлийн судалгаа
- ✓ 7а, 7б, 7е ангиудын Түүхийн анги дэвших шалгалтанд бэлтгэх жишиг даалгавартай ажиллаж буй байдлын судалгааг гаргаж шалгалтын дүн мэдээ, сурагчидтай ажиллаж буй байдлын мэргэжлийн багш, анги удирдсан багш, эцэг, эх асран хамгаалагч болон сургуулийн зүгээс хамтын гэрээг дүгнэн ажиллахад гол үзүүлэлт болж чадна.
- ✓ Хичээлээс гадуурхи үйл ажиллагааны судалгаа (музейн аялалд хамрагдаж буй байдлаар)

- ✓ Багшийн хөгжлийн дэвтэр хөтлөлтийн дэвтрийг хөтлөж дүгнэсэн.
- ✓ 2017 оноос тус сургуулийн 8-9-р ангийн давхардсан тоогоор 400 гаруй сурагчид АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн Санхүүжилтээр (World Learning), Иргэний Боловсролын Төв, Бүгд Найрамдахчуудын Хүрээлэн хамтран хэрэгжүүлж буй (Lead Mongolia) хөтөлбөрийн хүрээнд Иргэний Боловсролын Төвөөс зохион байгуулсан “Иргэн төсөл”-д хамрагдаж сурагчид өөрт болон сургууль, сургуулийн орчинд тулгамдаж буй асуудлыг тодорхойлон судалгаа хийн сургуулийн удирдах ажилтан, ажиллагсад болон түрээслэгч байгууллагын төлөөлөлтэй уулзалт, хэлэлцүүлэг явуулснаар судалгаа шинжилгээний арга барилд суралцаж бусдад хэрхэн нөлөөлөх арга барилд суралцлаа. Тус төсөлд идэвхитэй оролцон цомог бүтээн судалгаа шинжилгээ хийн ажилласан 120 гаруй сурагчид Иргэний боловсролын төвөөс батламж гардан авсан.

- **Эцэг эхийн оролцоо, хичээлээс гадуурх хүмүүжлийн ажлын үр дүн**

Сурагчдын эцэг эх, асран хамгаалагчидтай нээлттэй хаалганы өдрүүд, хичээлийн болон хичээлийн бус цагаар бус цагаар хамтран ажиллан мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч эргэх холбоотойгоор ажиллахад анхааран ажиллаж ирлээ. Гэсэн хэдий эцэг эх, асран хамгаалагчдын суралцагчидад тавьж анхаарал тогтмол жигд бус байгаа нь тэдний ажлын ачаалал, хүүхэддээ хандах хандлагатай холбоотой байж болох юм.

Сурагчидыг хичээлээс гадуур 9 дүгээр ангийн сурагчдыг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн Санхүүжилтээр (World Learning), Иргэний Боловсролын Төв, Бүгд Найрамдахчуудын Хүрээлэн хамтран хэрэгжүүлж буй (Lead Mongolia) хөтөлбөрийн хүрээнд Иргэний Боловсролын Төвөөс зохион байгуулсан “Иргэн төсөл”-д хамруулж нийгмийн харилцаанд идэвхитэй оролцуулах арга барилд суралцуулсан. Мөн түүнчлэн 7 дугаар ангийн 100 орчим сурагчдыг МҮМ, 9 дүгээр ангийн сурагчдыг Богд хааны ордон музей үзэж сонирхох аялалд хамааруулсан. МҮОНТ-ээс Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан “Ээждээ захидал бичээрэй” аянд сурагчдыг оролцуулсан бөгөөд иргэний боловсролын үйл ажиллагааны цаг, хичээлээс гадуур болон сургуулиас зохион байгуулсан олон үйл ажиллагаанд амжилттай хамруулан ажиллаа.

- **Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн биелэлт**

Сургуулийн нийгмийн ажилтантай хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн талаар хамтын гэрээ байгуулан ажиллаж биелэлтэнд нь анхаарал хандуулан ажиллаж байна.

- **“Гранд дизайн-23”-ын зорилго, зорилтын биелэлт**

- ✓ Зөв дадал хэвшилтэй, зөв хандлагатай, бие даан өөрийгөө хөгжүүлдэг, бусдыг сонсдог, аливаа зүйлд чин сэтгэлээсээ ханддаг, авьяас сонирхол, ур чадвараа нээн илрүүлж, хөгжих хүсэлтэй сурагч нэг бүрийг бэлтгэхэд анхаарал хандуулан ажиллав.
- ✓ Сурагчдын цаг баримтлах хандлагад өөрчлөлт оруулахад хичээлээр болон хичээлээс гадуурхи үйл ажиллагаагаар дамжуулан хамруулж сурлагын үнэлгээ болон идэвхи чармайлтын оноонд хамааруулан үзэх болсон.
- ✓ Сурагч, эцэг эх, асран хамгаалагч, анги удирдсан болон мэргэжлийн багшийн хамтын ажиллагааг дэмжин сургалтын үйл ажиллагаанд хамтран ажиллаа.
- ✓ Сургалтын хэрэглэгдэхүүнийг сургууль, мэргэжлийн багш, сурагчид болон бусад оролцогчидийн хамтын ажиллагааны үр дүнд сайжруулах зэрэгт тодорхой ахиц дэвшил гарган ажиллаа.

2. Мэдлэг чадварын ахиц амжилт

- **Гарааны болон оношлох үнэлгээ**

№	АНГИ БҮЛЭГ	СУРАГЧДЫН ТОО	ҮНЭЛГЭЭНИЙ ТҮВШИН							
			I	II	III	IV	V	VI	VII	VIII
1	7а	52	0	0	2	2	14	18	15	1
2	7б	50	0	0	1	9	13	18	9	0
3	7д	54	0	2	5	9	13	14	11	0
4	7е	54	0	2	7	6	10	12	14	3
5	9б	39 (46)	0	0	2	6	11	11	9	0
6	9е	40	0	0	3	0	12	11	13	0
7	11а	42	0	4	4	8	10	8	7	0
8	11б	37	0	1	3	7	10	11	3	3
9	11д	36	0	2	3	10	12	6	4	0
НИЙТ		404 (411)	0	11	30	57	105	109	85	7

Сураглцагчдаас түүхийн хичээлээр гарааны онооны сорилыг 2017-2018 оны хичээлийн жилийн судалсан агуулгын дагуу 6, 8, 10 дугаар ангийн судлагдахууны агуулгын хүрээнд боловсруулж авсан. Харин хагас жилийн үнэлгээний сорилыг I, II улирлын хичээлийн агуулгын хүрээнд боловсруулж авсан ба 7, 9, 11 дүгээр ангийн судлагдахууныг анги тус бүрийн онцлогт тохируулан амаар, сорил хэлбэрээр авсан.

Даалгаврын сан бүтээх, харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх гэсэн бүтэцтэй. Гарааны үнэлгээний түвшин доогуур байсан нь зуны амралтын хугацаанд сурагчид өөрсдийн эзэмшсэн мэдлэг, чадвар, дадлаа мартсан байдал сорилыг засах явцад ажиглагдсан бол хагас жилийн үнэлгээ харьцангуй дээшилсэн байдал ажиглагдаж байна.

	Анги	Сурагчдын тоо	Үнэлгээний түвшин							
			I	II	III	IV	V	VI	VII	VIII
гараа	7а	52	0	0	2	2	14	18	15	1
I хагас жил		50	0	1	2	1	20	15	8	3
гараа	7б	50	0	0	1	9	13	18	9	0
I хагас жил		52	1	1	1	0	13	14	16	6
гараа	7д	54	0	2	5	9	13	14	11	0
I хагас жил		56	7	3	1	0	17	5	15	8
гараа	7е	54	0	2	7	6	10	12	14	3
I хагас жил		56	0	2	0	0	14	15	11	14
гараа	9б	39 (46)	0	0	2	6	11	11	9	0
I хагас жил		44	0	0	0	2	21	10	7	4
гараа	9е	40	0	0	3	0	12	11	13	0
I хагас жил		32	1	0	3	2	5	12	6	3
гараа	11а	42	0	4	4	8	10	8	7	0
I хагас жил		41	0	0	0	0	8	10	12	11
гараа	11б	37	0	1	3	7	10	11	3	3
I хагас жил		39 (40)	0	0	0	0	9	11	15	4
гараа	11д	36	0	2	3	10	12	6	4	0
I хагас жил		36 (52)	0	0	0	0	5	9	12	10
гараа		404 (411)	0	11	30	57	105	109	85	7
I хагас жил		406 (423)	9	7	7	5	112	101	102	63
Нийт			-9	+4	-23	-52	+7	-8	+17	+56

7 дугаар ангийн сурагчдын гарааны оноонд дүн шинжилгээ хийж үзэхэд суралцагчдын даалгавар гүйцэтгэлд эх сурвалжтай ажиллах, шалтгаан үр дагаварыг, он тоололтой бодлого, шулуунд байрлуулахдаа анхаарал хандуулах ажиллах хэрэгтэй бол

сорил, үгсийн утга тайлбарлахдаа сайн гүйцэтгэлтэй байлаа. Харин хагас жилийн мэдлэг чадварын сорилыг 7 дугаар ангиас аман хэлбэрээр 3 асуултайгаар авсан ба дэлхийн болон монголын түүхийн хоёр асуулт, газрын зурагтай ажиллах даалгавартай байлаа. Сурагчид шалгалтанд төдий л сайн бэлдээгүй, газрын зурагтай ажиллах, яриж тайлбарлах чадвар сул хөгжсөн байгаад анхаарал хандуулан ажиллах шаардлагатай. Багш, суралцагч, эцэг эхийн зүгээс хичээлийн явцын гүйцэтгэл болон гэрийн даалгаварт тогтмол анхаарал хандуулан хяналт тавьж үнэлгээ өгөх, анги тус бүр, суралцагчийн хувийн онцлог байдлыг харгалзан үзэх нь сурлагын үзүүлэлтэнд сайнаар нөлөөлөх боломжтой.

9 дүгээр ангийн сурагчдын түүх хичээлийн гарааны оноонд шинжилгээ хийж үзэхэд эх сурвалж, тохиолдолтой ажиллах, шалтгаан үр дагаврыг тайлбарлахдаа гүйцэтгэл сайн байсан бол он тооллын бодлого бодох, сорил, жиших, логик уялдаа холбоо, зүй тогтолыг гаргасан даалгавар дээр анхаарал хандуулан ажиллах нь чухал байгаа бөгөөд төгсөх ангийн сурагчдын хувьд өмнөх жилүүдийн үзэж судалсан зүйлээ сэргээн санах, түүнийг хэрэглээ болгон ажиллах бусад сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглах бие даан ажиллах талд илүүтэй анхаарах нь чухал байсан. Хагас жилийн үнэлгээг тооцохдоо мэдлэг чадварын үнэлгээнд тулгуурласан ба сорил даалгаврын материалыг Боловсролын үнэлгээний төвийн улсын шалгалтын сорилд тулгуурлан боловсруулсан болно. Сорилд дүн шинжилгээ хийхэд сурагчид шалгалтанд сайн бэлтгээгүй байгаа нь ажиглагдсан ба сурвалж, баримтыг задлан шинжлэх, тайлбарлах даалгавартай ажиллах чадвар сул байлаа. 9 дүгээр ангийн сурагчид түүхийн хичээлээр улсын шалгалт өгөх ба цаашид бие даан болон хамтран жишиг даалгавартай ажиллах, цээжлэх, тогтоох, учир шалтгаан, зүй тогтолыг танин мэдэх тайлбарлахад анхаарал хандуулан ажиллах шаардлага байсан.

11 дүгээр ангийн сурагчид түүх хичээлийн гарааны оноонд шинжилгээ хийж үзэхэд эх сурвалж, тохиолдолтой ажиллах даалгавар дээр сайн ажилласан бол сорилтой ажилласан байдал нь хангалтгүй байлаа. Түүнчлэн сурагч бүрийн даалгавар гүйцэтгэл харилцан адилгүй байсан ба энэ нь тэдний эзэмшсэн мэдлэгийн түвшин өөр өөр байгааг харуулж байгаа бөгөөд сурагчдын хувийн онцлог зэргийг харгалзан үзэж хичээлээр хөгжүүлэх нь зөвхөн багш суралцагчдын хамтын ажиллагаа бус эцэг эх, асран хамнаалагчдын нөлөө чухал байгааг харуулж байна.

Харин хагас жилийн үнэлгээг тооцохдоо I, II улирлын хичээлийн агуулгаар сорил боловсруулан үнэлсэн. Үнэлгээнд дүн шинжилгээ хийж үзэхэд сурагчид сорилтой ажиллахад харьцангуй сайн харин дасгалын зураг, эх сурвалжтай ажиллах даалгавартай ажиллахдаа харьцангуй сул үнэлгээ авч байсан. Цаашид бие даан ажиллах, илтгэх, танин мэдэхүйгээ хөгжүүлэх, багаар ажиллах арга барилаа хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай.

7-11 дүгээр ангийн түүх хичээлийн гарааны оноо болон хагас жилийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж үзэхэд цаашид багш, суралцагч, эцэг эхийн хамтын ажиллагаанд анхаарал хандуулан эргэх холбоотойгоор хамтран ажиллаж сурагчид өөрийн эзэмшсэн мэдлэг, ойлголт, дадлыг сэргээн санаж түүнийг байнга ашиглаж хэрэглээ болгодог шинэ үзсэн мэдлэгийг бүтээж, багшийн чиглүүлэгтэйгээр хөгжих нь чухал юм.

- **Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалт /Moodle/**

2018-2019 оны хичээлийн жилд Түүх, иргэний боловсролын судлагдахууны төлөвлөл хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө, төлөвлөлт, ээлжит болон нэгж хичээлийг хамтран бэлтгэн, хэлэлцүүлэг зохион байгуулж харъяалагдах менежерээс зөвлөгөө авч баталгаажуулж сургалтанд амжилттай хэрэгжүүлсэн. III, IV улирлын ээлжит болон нэгж хичээлийн төлөвлөлтийг болон зарим цахим хичээлийг байршуулсан.

№	СУДЛАГДАХУУН	Бүлэг	НЭГЖ ХИЧЭЭЛ		ЭЭЛЖИТ		САЙЖРУУЛСАН ХИЧЭЭЛ
			Боловсруулвал зохих	Боловсруулж баталгаажуулсан	Боловсруулвал зохих	Боловсруулж баталгаажуулсан	
1	Түүх	7	2	2	35	35	5
2		9	2	2	35	35	3
3		11	2	2	16	16	6
4	Иргэний боловсрол	7	2	2	18	18	6
		9	2	2	18	18	6
НИЙТ			10	10	122	122	26

• **Стандарт хэрэгжилт**

I хагас жилийн үнэлгээ

№	АНГИ БҮЛЭГ	СУРАГЧДЫН ТОО	ҮНЭЛГЭЭНИЙ ТҮВШИН							
			I	II	III	IV	V	VI	VII	VIII
1	7а	50	0	1	2	1	20	15	8	3
2	7б	52	1	1	1	0	13	14	16	6
3	7д	56	7	3	1	0	17	5	15	8
4	7е	56	0	2	0	0	14	15	11	14
5	9б	44	0	0	0	2	21	10	7	4
6	9е	32	1	0	3	2	5	12	6	3
7	11а	41	0	0	0	0	8	10	12	11
8	11б	39	0	0	0	0	9	11	15	4
9	11д	36 (53)	0	0	0	0	5	9	12	10
НИЙТ		406 (423)	9	7	7	5	112	101	102	63

II хагас жилийн үнэлгээ

№	АНГИ БҮЛЭГ	СУРАГЧДЫН ТОО	ҮНЭЛГЭЭНИЙ ТҮВШИН							
			I	II	III	IV	V	VI	VII	VIII
1	7а	50	0	0	1	5	13	14	13	4
2	7б	50	0	0	0	0	14	6	16	14
3	7е	56	0	0	0	0	10	9	22	15
4	9б	44	0	0	0	0	3	7	19	15
5	9е	32	0	0	0	0	6	7	15	4
6	11а	41	0	0	0	0	0	0	13	28
7	11б	39	0	0	0	0	0	0	9	30
8	11д	53	0	0	0	0	0	0	8	45
НИЙТ		365	0	0	1	5	46	43	115	155

I, II хагас жилийн үнэлгээний харьцуулалт

№	Анги	Сурагчдын тоо		Үнэлгээний түвшин															
				I		II		III		IV		V		VI		VII		VIII	
		I	II	I	II	I	II	I	II	I	II	I	II	I	II	I	II	I	II
1	7а	50	50	0	0	1	0	2	1	1	5	20	13	15	14	8	13	3	4
2	7б	52	50	1	0	1	0	1	0	0	0	13	13	14	6	16	16	6	14
3	7д	56		7		3		1		0		17		5		15			8
4	7е	56	56	0	0	2	0	0	0	0	0	14	10	15	9	11	22	14	15
5	9б	44	44	0	0	0	0	0	0	2	0	21	3	10	7	7	19	4	15
6	9е	32	32	1	0	0	0	3	0	2	0	5	6	12	7	6	15	3	4
7	11а	41	41	0	0	0	0	0	0	0	0	8	0	10	0	12	13	11	28
8	11б	39	39	0	0	0	0	0	0	0	0	9	0	11	0	15	9	4	30
9	11д	36	53	0	0	0	0	0	0	0	0	5	0	9	0	12	8	10	45
НИЙТ		406	365	9	0	7	0	7	2	5	5	112	45	101	43	102	115	63	155
					-0		-0		-5		-5		-67		-58		+13		+92

- **Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт**

2018-2019 оны хичээлийн жилд I-IV улиралд өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж харъяалагдах менежерээр баталгаажуулан хэрэгжүүлэн ажиллаа. Үүнд:

- ✓ Хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө хуваарийн дагуу баталгаажуулж, хуваарийн дагуу хичээл үйл ажиллагаа зохион байгуулж, суралцагчдыг бодитой үнэлж дүгнэсэн.
- ✓ Сургууль, дүүрэг, нийслэл, БМДИ, бусад байгууллагаас зохион байгуулах сургалт, семинар, үйл ажиллагаанд оролцож багшийн болоод хувь хүний хөгжилд тодорхой ахиц дэвшил гарсан.
- ✓ Сайн хичээл, үйл ажиллагаа, түгээн дэлгэрүүлэлт /өөрөө болон хамтран сурууль, дүүрэг, нийслэлийн хэмжээнд/ цахим орчинд (Moodle) байршуулсан.
- ✓ Сургалтанд хэрэглэгдэж буй сургалтын хэрэглэгдэхүүнийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн ашигласан.
- ✓ Гадаад хэл, компьютерийн хэрэглээний түвшинг тодорхой түвшинд ахиулж мэдээлэл авах, боловсруулах зэрэг хэрэглээнд ахиц гарсан.
- ✓ Түүх, иргэний боловсролын судлагдахууны дүүрэг, нийслэл болон бусад байгууллагаас зохион байгуулдаг уралдаан тэмцээн, олимпиадад сурагчдыг бэлтгэн оролцуулж, хөгжүүлсэн.
- ✓ Сургууль, дүүрэг, нийслэл, улс, бусад байгууллагас зохион байгуулсан үйл ажиллагаанд амжилттай оролцсон.
